



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ  
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

## ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2024 БАГА БОЛОВСРОЛ



# МОНГОЛ ХЭЛ

БАГАНАН КОД  
НААХ ХЭСЭГ

Аймаг / дүүрэг: .....

Сум / сургууль: .....

Анги / бүлэг: .....

Сурагчийн овог: .....

Сурагчийн нэр: .....

Сурагчийн код: .....



## САНАМЖ

- Эхийг уншаад, даалгаврыг зааврын дагуу гүйцэтгээрэй.
- Даалгаврыг 40 минутад гүйцэтгээрэй.
- Өгсөн зайд цэвэр гаргацтай бичнэ үү.

### Гар чийдэн

Баатар ах дэлгүүрээс гар чийдэн худалдан авсан байлаа. Хачин гоё, хурц тод, дөрвөлжин чийдэн байв. Ийм чийдэнтэй болох сон гэж аль хэдийнээс хүссэн маань одоо биелэх нь тэр дээ! Үдшийн бүрий болох үед дүү:

- “Ах аа! Хоёулаа гадаа унтъя. Гадаа унтахад сайхан байдаг шүү дээ” гэв.

Бид хөнжлөө аваад, гарлаа. Харанхуй байгаа ч бүлээн салхитай, таатай сайхан байв. Жаахан хэвтэж байснаа дүү:

- Би Баатар ахын чийдэнг сэм авсан. Хоёул чийдэнгээ асааж үзэх үү?

- Хааш нь тусгах вэ? Хонь үргэвэл яана?

- Үргэхгүй ээ. Яагаад гэвэл хашаан дотор байгаа шүү дээ

Хоёулаа хонины нүдийг харъя. Шөнө ямар өнгөтэй байдаг бол?

- Нээрээ хонины нүд шөнө ямар байдгийг харах нь сонин шүү дээ.

Чийдэнгийн цагаан туяа хонины хашаа хүрмэгц бид хоёр гайхсандаа дуу алдав. Үгүй мөн хачин шүү! Машинуудын явахыг зөвшөөрч асдаг гэрэл шиг нүднүүд энд тэндгүй харагдах нь тэр.

За одоо морины нүд үздэг хэрэг. Ямар догь байх бол? Аягүй бол “Анхаар” гэсэн шар дохио шиг гэрэлтэй ч байж мэднэ дээ.

Бид аргамжааны гадаснаас холгүйхэн зогсож байгаад морьд руу чийдэн тусгаад орхисон чинь юун нүдийг нь үзэхтэй манатай хачин юм боллоо. Морьд чийдэнгийн хурц гэрлээс үргэж аргамжаагаа таслаад пижигнэж алга боллоо.

Өглөө Баатар ах биднийг дуудаж

- Харж байна уу? Одоо хөл дүүжлэх юм юу ч алга. Морьдыг та хоёр үргээсэн байх даа! Тэгсэн үү, үгүй юу? Бид хоёр дуугүй зогсож байлаа.

- “Та хоёр морьдоо олж ир” хэмээн ах бид хоёрыг явууллаа. Бид морьдоо олох гэж мөн ч хол явган явсан даа. Болчимгүй явдал бурууддагийг тэгэхэд л ойлгосон юм.

1 “За одоо морины нүд үздэг хэрэг. Ямар догь байх бол? Аягүй бол “Анхаар” гэсэн шар дохио шиг гэрэлтэй байж ч мэднэ дээ” гэсэн үйл явдал өрнөх болсон шалтгаан аль вэ?

А. Чийдэнгийн цагаан туяа хонины хашаа хүрмэгц бид хоёр гайхсандаа дуу алдав.

Б. Нээрээ, хонины нүд шөнө ямар байдгийг харах нь сонин шүү дээ.

В. Чийдэнгийн цагаан туяа хонины хашаа хүрмэгц бид хоёр гайхсандаа дуу алдав.

Г. Үгүй мөн хачин шүү! Машинуудын явахыг зөвшөөрч асдаг гэрэл шиг нүднүүд энд тэндгүй харагдах нь тэр.

2 Баатар ах “Та хоёр л үргээсэн байх даа!” гэж хэлсний учир шалтгааныг эхээс сонгон бичээрэй.

.....

.....

3 Зохиолын баатрын үзэл бодолд гарсан өөрчлөлтийг харуулсан өгүүлбэр аль вэ? сонгож дугуйлаарай.

А. Ийм чийдэнтэй болох сон гэж аль хэдийнээс хүссэн маань одоо биелэх нь тэр дээ!

Б. Нээрээ, хонины нүд шөнө ямар байдгийг харах нь сонин шүү дээ.

В. За одоо морины нүд үздэг хэрэг. Ямар догь байх бол?

Г. Болчимгүй явдал бурууддагийг тэгэхэд л ойлгосон юм.

Б. Үзэл бодолд гарсан өөрчлөлтийн шалтгааныг тайлбарлан бичээрэй.

.....

.....

4 А. Адилтган дүрсэлсэн хэсгийг сонгож  тэмдэглэнэ үү.

Аягүй бол “Анхаар”  
гэсэн шар дохио шиг  
гэрэлтэй ч байж  
мэднэ дээ.

Машинуудын явахыг  
зөвшөөрч асдаг гэрэл  
шиг нүднүүд энд  
тэндгүй харагдах нь

Морьд чийдэнгээс  
үргэж аргамжаагаа  
таслаад пижигнэж  
алга боллоо.

Б. Ямар шинжээр адилтгасан болохыг тайлбарлан бичээрэй.

.....

.....

5 Морьдыг нэг юм үргээж, та хоёр л үргээсэн байх даа! Тэгсэн үү? Үгүй юу? гэж асууж байхад хүүхдүүд ямар царай гаргасан бол? сонгож дугуйлаарай.

А. айсан      Б. үл тоосон      В. гэмшсэн      Г. ичсэн

6 Эхийн гол санааг илэрхийлэхэд өгсөн өгүүлбэрүүдээс чухал нь аль вэ? Чухлаас эхлэн дугаарлаарай.

Болчимгүй явдал бурууддагийг тэгэхэд л ойлгосон юм.

Морьдыг нэг юм үргээж та хоёр үргээсэн байх ёстой даа!

Бид морьдоо олох гэж мөн ч хол явган явсан даа.

7 Зурагт тохирох холбоо үгийг сонгоорой.



хуулсан цаас

хуйлсан цаас

хуульсан цаас





Даалгаврын дугаар	Авах оноо	
I		
II		
III		
IV		
V		
VI		
VII		
VIII	A	
	Б	
	B	

